БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр Дугаар А/260 Булган сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын IX Хуралдааны IX/16 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд Булган сумын орон сууцнуудын гадаа хуванцар сав ангилах хогийн сав байрлуулах (15-аас доошгүй) ажлыг хүлээн авах Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: -С.Алтанзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: -М.Алтанцэцэг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
-А.Ганболд (Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн дарга)
-Б.Солонго (Булган сумын Жаргалант багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: - Г.Нарангэрэл (Булган сумын Хөгжлийн бодлогын мэргэжилтэн)

2.Булган сумын орон сууцнуудын гадаа хуванцар сав ангилах хогийн сав байрлуулах (15-аас доошгүй) ажлыг зохих хууль, журмын дагуу 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс өдрийн дотор хүлээн авч, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж ажиллахыг Ажлын хэсэг (С.Алтанзул)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

6320220318